

Living the Lotus

6
2021

VOL. 189

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Хэрэгжүүлэх ба суралцах хоёр зам мөр

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 188 (2021.06)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Одоогийн нийгэмд мэдлэг оюуны бядаараа гайхан шагшруулах хүмүүс олон болсон. Харин тийм хүмүүс амьдралын асуудалд төөрөгдөн, шийдвэр гаргаж чадалгүй мэдрэлийн ядаргаанд орох нь их байдаг. Асар их мэдээллийн урсгал дунд буй одоогийн нийгэмд авьяас чадвартай байх тусам зовж шаналах нь их болжээ.

Бид бүхэн сайхан яриаг олон дахин сонсоод өөрөө өөртөө бол нилээд гэгээрсэн мэт болдог. Гэвч мэдлэгтэй боллоо гээд тэр нь жинхэнэ утгаараа өөрийн болсон гэсэн үг биш. Хэрэгтэй зүйл сонссон бол түүнийгээ хэрэгжүүлж үзэхгүй л бол үнэндээ юу ч ойлгохгүй.

Би бол “Энэ ч ёстой зөв юм сонсоод авлаа даа” гэж бодсон бол тэр дор нь хэрэгжүүлж үздэг. Тэгэхээр улам илүү ойлгодог. Өөрийн болж байна гэсэн үг. Сургаалын дагуу итгэж, хэрэгжүүлэх гэдэг нь шашин шүтлэг юм шүү дээ

Мэдээллийн нийгэм болж хөгжихийн хирээр өөрийн итгэл үнэмшлээ сэтгэлдээ бат бөх хадгалах чухал бөгөөд үүний тулд хэрэгжүүлэх ба суралцах хоёр зам мөр зайлшгүй шаардлагатай.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X86-87

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгааяа гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирах

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Өөрийн боломжийг олж харах

Цагаан Лянхуа Судрын “Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвагийн хотол үүдийг өгүүлэх бүлэг”-ийг “Хутагт Мэлмийгээр Болгоогч Судар” ч гэж ч хэлдэг ба олноо таашаагдсан бүлэг юм. Зовж шаналах үедээ нэгэн сэтгэлээр Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирваас тэр дороо дуу хоолойг тань сонсож, аврах болно гэсэн энэ бүлгийн сургаалаас урам зориг аван энэ бодисадвад итгэж, бишрэн шүтэх хүн олон учраас тэр билээ. Зөвхөн энэ хэсгийг нь л аваад үзвэл бурхан тэнгэрээс ямар нэг бодиг ашиг тус хүссэн шүтлэг мэт санагдаж магадгүй. Гэхдээ Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирах нь бурханы сургаалын талаар үнэн сэтгэлээсээ бодож үзэх учиг нь болдог гэж үзвэл энэ ч бас иггэл үнэмшлийн үүдийг нээх чухал алхам хэмээн эрхэмлэн үзэх ёстой зүйл болов уу.

Хэдий тийм ч гэсэн Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирах төдийд аз жаргалтай болж, аврагдна гэж сургасан сургаал гэж бодохгүй байна. Яагаад гэвэл энэ бүлэг нь Цагаан Лянхуа Судрын нэг бүлэг бөгөөд тус судрын мөн чанарыг өөртөө шингээсэн байдаг.

Түүний нэг нь өөрт байгаа боломжийг олж анзаарахын чухлыг сургасан.

“Хутагт Мэлмийгээр Болгоогчийн хувилгаан хүч” гэсэн үг бий. Бид өдөр бүр судар уншихдаа “Хутагт Мэлмийгээр Болгоогчийн рид хувилгааны хүчээр орчлонгийн гаслангаас амьтдыг аварч чадмой.” хэмээн уншдаг. Энэхүү үгийн утга агуулгыг Үүсгэн байгуулагч “Зовлон бэрхшээлтэй учирсан үед бий болдог дотоод хүч бол эсрэгээрээ зовлонгоос ухаарал авч, өсч хөгжих гайхалтай сэтгэлийн хүч байдаг.” хэмээн тайлбарлажээ.

Зовлонгийн ёроолоос өндийн босч, тэрхүү зовлон бэрхшээл бүрээс суралцан хөгжиж чадах далдын хүч бидэнд байдаг бөгөөд түүнийг “Хутагт Мэлмийгээр Болгоогчийн хувилгаан хүч” гэдэг. Яруу найрагч Ямао Сансэи гуай бидний дотор орших амьдралын эх булаг амьдрах хүч чадвартаа итгэх нь Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирахын утга юм хэмээн хэлжээ.

Өөрөөр хэлбэл Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва гэдэг бол та өөрөө юм. Өөрийнхөө боломж, дотоод хүчинд итгэж, чин сэтгэлээсээ залбирах аваас бид бүхний зүрх сэтгэлээс амар амгалан болоод сэтгэлийн их хүч тэнхээ оргилон гарч ирэх болно. Зовлонгоос аврагдана гэдэг нь үүнийг хэлж буй билээ.

Бүх хүнийг аврах хүсэл

Бид бүхэн зовлон шаналалд цөхрөх үедээ үүрд үргэлжлэх зовлон гэж үгүй болохыг гэнэт ухааран хүлээн зөвшөөрч, ганцаардаж шаналсандаа үхэхийг хүсэх үедээ хайрлан харж хандаж байсан хүмүүсээ санан амьдрах эрч хүчтэй болох үе байдаг. Тэр мөч бол бүх юмс хувирч өөрчлөгддөг, юу ч ганцаар оршин тогтнодоггүй хэмээх орчлонгийн хуулийг ухаарч, шинэ амьдрал нээгдсэн мөч юм. Тухайн үедээ түүнийг бурханы сургаал болохыг анзаараагүй ч, өөрийн бэлгэ, билгийн хүч (гайхамшигт хувилгаан хүч)-ээр бурхны сургаалыг ухаарч хөл дээрээ босч чадсан гэсэн үг.

Үнэхээр хэцүү үед өөрийн мэдэлгүй “Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва минь туслаач” гэж залбирдаг хүн байж ч магадгүй. Тэгсэн ч болно. Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад сэтгэлийн гүнээс сүсэглэх цэвэр ариун сэтгэл хийгээд өөрийн дотор орших Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва хоёр нэгэн цул болсноор хүний жинхэнэ дотоод хүч ажиллаж эхэлдэг тул эхлээд бодит амьдралын эрх ашгийн төлөө залбирахад болохгүй зүйл байхгүй.

“Уран арга жинхэнэ үнэн рүү хөтөлдөг” гэдэг үг ийм учиртай. Тэгэхээр энэ бүлэгт Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирах гэсэн уран аргаар дамжуулж бурханлаг чанараа олж анзаарах юм бол ямар ч хүн гарцаагүй аз жаргалтай болж, оюун санааны эрх чөлөөнд хүрнэ хэмээх үнэнийг сургасан гэж хэлж болно.

Мөн энэ сударт Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадва янз бүрийн аргаар хүмүүсийг зовлонгоос ангижруулж байгаа талаар олон дахин өгүүлдэг. Энэ нь ч гэсэн бүх хүмүүсийг аврах юмсан гэсэн сэтгэл бидэнд ч гэсэн байдаг гэдгийг ухааруулах гэсэн нэгэн уран арга бус уу. Хутагт Мэлмийгээр Болгоогч бодисадвад залбирахаар дамжуулж мянган мутарт бодисадва мэт өөрийн дотор орших “Мянган гараа сунгаад ч болов хүмүүст аз жаргал, амар амгаланг өгөх юмсан” гэсэн сэтгэлийг анзаарах чухал. Ингэснээр өөрөө бодисадва болж, хүмүүсийн төлөө сургаалыг хэрэгжүүлж эхэлдэг. Энэ ямар чухал болохыг тус бүлэгт өгүүлжээ.

«Косей» 2021 оны 6 сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Хотолд Сайн бодисадвагийн зоригжуулсныг өгүүлэх 28 дугаар бүлэг

Зүүн зүгийн Эрдэнийн Сүр Эрдэнэт Дээд хаан бурханы орноос Цагаан Лянхуа Судрыг сонсохоор ирсэн Хотолд Сайн бодисадва бээр сургаалын утга агуулгыг сонсох төдийд ихэд бишрэн “Хожмын ертөнцөд энэхүү сургаалыг тогтоон авах хүмүүнийг би заавал хамгаалах болно.” гэсэнд Шагжамүни бурхан хариуд нь магтан “Хотолд Сайн бодисадва мэт үйл хийх хүнийг би ч бас хамгаалах болно.” хэмээн айлддаг. Өөрөөр хэлбэл уг бүлэг нь ирээдүйд Цагаан Лянхуа Судрын сургаалыг хэрэгжүүлэх хүмүүнийг урамшуулан дэмжсэн бүлэг юм.

Судрын сургаалыг хэрэгжүүлж байж ач буянаа өгнө

Яагаад хамгийн сүүлийн бүлэгт Хотолд Сайн бодисадва гарч байна вэ хэмээвээс түүнд гүн гүнзгий утга агуулагдаж буй. Хотолд Сайн бодисадваг “Учир шалтгаан, магад үнэнээр тогтоох, хэрэгжүүлэх” үйлийг эрхшээгч бодисадва гэж үздэг боловч цагаан зааны хааныг хөлөглөж буйгаар дүрсэлдэг нь (Заан голоор гатлахад ч хөл нь усны ёроолд гишгэсэн байдаг) бусад хоёр чадвараасаа илүү “Хэрэгжүүлэх” үйлийг тууштай хийдэг бодисадва болохыг илэрхийлсэн.

Цагаан Лянхуа Судрын эхэн хэсгийн гол дүр бодисадва нь билиг оюуны билэгдэл Манзушири бодисадва, дунд хэсэгт (Ялангуяа “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх бүлэг”) нигүүлсэхүй сэтгэлийн бэлгэ тэмдэг Майдар бодисадва гардаг. Хамгийн сүүлийн төгсгөл хэсэгт “Хэрэгжүүлэх” үйлийн бэлгэ тэмдэг Хотолд Сайн бодисадва гардаг. Энэ нь Цагаан Лянхуа Судрын сургаалыг сонсоод хамаг юмсын жинхэнэ дүр төрхийг харах бэлгэ оюуныг ухаарч, мөнх Язгуурын Бурханы агуу нигүүлсэхийн ачаар амьдарч буй гэсэн орчлонгийн хуулийг гэгээрлээ гээд түүнийгээ хэрэгжүүлэхгүй л бол ямар ч утгагүй болохыг илэрхийлж буй хэрэг гэдгийг хэлэхэд илүүц биз ээ.





Дөрвөн сургаалыг биелүүлэх

Уг бүлэгт Шагжамүни бурханы маш чухал сургаал гардаг. Тэр нь Хотолд Сайн бодисадвагийн асуусан асуултад дараахь байдлаар хариулдагаар гарна.

“Хэрэв гүн сүсэг бишрэлтэй бурханы шавь нар дараах дөрвөн зүйлсийг биелүүлбэл Бурханыг нас нөгчсөний хойно ч энэхүү Цагаан Лянхуа Судрын сургаалыг эзэмшсэнтэй адил болох бөгөөд түүний сургаалын жинхэнэ ач буяныг олж эдэлнэ.

Нэгдүгээрт, бурхадын ивээл хамгаалалд байдаг гэдэгтээ гүн итгэлтэй байх.


Хоёрдугаарт, өдөр тутмын амьдралдаа сайн үйлийг хийж, буянаа арвижуулахын төлөө хичээн зүтгэх.

Гуравдугаарт, зөв сургаалыг эрхэмлэн дээдлэх хүмүүсээр хүрээлүүлэх.

Дөрөвдүгээрт, ертөнцийн хүмүүстэй хамт аврагдах нь жинхэнэ аврал болохыг ухаарч, өөрийн идэвх санаачлагаар олон хүнийг аврах сэтгэлтэй байх.

Өдийг хүртэл нарийвчлан сургасаар ирсэн сургаалуудыг жирийн хүмүүст ч гэсэн ойлгомжтой, хэрэгжүүлэхэд хялбар байх үүднээс ийнхүү товч бөгөөд тодорхой дүгнэн хэлжээ. Судрын сургаалын хэт гүн гүнзгий утга агуулгыг ойлгохгүй бага зэрэг эмээж байсан хүмүүс үүгээр дамжуулж сая нэг ухааран “Би ч гэсэн сургаалыг ойлгож, хэрэгжүүлж чадах юм байна.” гэсэн урам зориг орсон нь гарцаагүй. Үнэхээр “Гайхамшигт Ном Цагаан Лянхуа Судар”-ын төгсгөлд нийцсэн утга агуулга бүхий сургаал юм.





Олон улсын хэлтсийн даргын булан

Гайхамшигт амь нас

Хутагт мэлмийгээр болгоогч бодьсадвагийн хотол үүдийг үгүүлэх бүлэг бол миний хувьд мартагдашгүй дурсамж шингэсэн бүлэг.

1960 онд 3 дахь хүүхдээ төрүүлэх гээд хүч тэнхээ сул байсан ээж минь Хутагт мэлмийгээр болгоогч бодьсадвагийн хүчинд залбирсаар намайг төрүүлсэн гэдэг. Зүүн хойд зүгийн хөдөө нутагт эх баригчийн тусламжтайгаар гэртээ төрсөн юм. “Дуншиж эхлэх хүртлээ чанга хоолойгоор Хутагт мэлмийгээр болгоогч бодьсадва бүлгийг уншсан юм даа” гэж ээж минь ярьдаг.


Харин би төрөхдөө ямар ч хөдөлгөөнгүй, уйлах дуу ч байхгүй, хөхөрсөн байдалтай байсан гэсэн. Тэр даруй ойрхон байдаг хариуцсан эмчийг дуудаж, байдаг бүх арга хэмжээг авсан ч нэмэргүй, яахаа мэдэхгүй мөч байсан боловч эмч, эх баригчийн шаргуу түргэн тусламжийн ачаар би амьсгалж эхлэн, ямар нэгэн өвчин эмгэггүй эрүүл саруул амь насыг олсон гэдэг.

Би энэ бүлгийг унших бүртээ амь насыг заяасан олон хүний ач буянд талархдаг. Үнэхээр гайхамшигтайгаар амь насыг олсон энэ ач буяныг хариулах хамгийн чухал үйл бол Лянхуа судрыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх явдал гэж боддог.



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>